

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (✓) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ- т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төсөлд шинээр томилогдсон Засгийн газрын гишүүдээс санал авах шаардлагатай болсон. Иймээс хуулийн төслүүдийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас буцаан авсан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2-т заасны дагуу Нийгмийн даатгалын тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа болон үзэл баримтлалын төслүүдийг боловсруулж, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасны дагуу хамтран батлахаар 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.		✓		
2.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг яамны удирдлагуудад 11 дүгээр сарын 17, 18, 22-ны өдрүүдэд танилцуулж, хэлэлцэв.	✓			
3.	Шинэчлэн батлуулахаар хүргүүлсэн үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг дахин боловсруулж байна.	✓			
4.	Тэтгэвэр тогтооход баримтлах дараалсан жилийг 7-5 жил болгохтой холбоотой тооцоо, судалгаа, мэдээллийг Нийгмийн бодлогын байнгын хороо болон яамны удирдлагуудад бэлтгэж өгөв.		✓		
5.	“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэх шинжээчдийн ажлын хэсгийн 12 дахь хэлэлцээг 2022 оны 12 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд цахимаар зохион байгуулах саналыг хүргүүлэв.			✓	
6.	МУ-ын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн тухай хэлэлцээрийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахаар танилцуулга бэлтгэн хүргүүлсэн.		✓		
7.	Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын А/214 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Ажилтны мэргэшлийн зэрэг тогтоох, олгох, баталгаажуулах нийтлэг журам”-ыг боловсруулахаар ажиллаж байна.			✓	
8.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 07 дугаар сарын-01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулан Засгийн газрын “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 338 дугаар тогтоол батлагдан хэрэгжиж байна. Засгийн газрын тогтоолын дагуу Хөдөлмөрийн сайд болон Сангийн сайдын 2015 оны “Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний журам, хураамжийн хэмжээ батлах тухай” А/108/149 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болгохоор хамтарсан тушаалын төслийг боловсруулан батлууллаа.			✓	
9.	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/162 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцоо, судалгаа бусад баримт бичгийн хамт боловсруулах ажил хийгдэж байна. Ажлын хэсгийн гишүүдээс боловсруулсан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2022 оны 01 дүгээр сард 01/219 тоот, 07 дугаар			✓	

	сард 01/1861 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. ХЗДХ-ийн сайдаас 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 01/3652 тоот албан бичигт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг “Шинэ сэргэлтийн бодлого”-той нийцүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн эх үүсвэр нь голчлон гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийн орлогоос хамааралтай байгааг өөрчилж, санг илүү тогтвортой эх үүсвэрээс бүрдүүлэх чиглэлд санал ирүүлсэнийг, үзэл баримтлалын төслийн 1.2 дугаар хэсгийн 5-д болон 3 дугаар хэсгийн 4-т тус тус тодорхой тусгаж сайдаар батлуулан, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэхээр ажиллаж байна.				
10.	<p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформын үндсэн дэд систем болох “Ажил зуучлалын онлайн портал”-ыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр улсын хэмжээнд амжилттай нэвтрүүллээ.</p> <p>“Ejob” платформ нь 3 дэд систем 13 модулиас бүрдэх бөгөөд Монгол Улсын хэмжээнд ажил хайгч, ажил олгогчдыг холбох ажил зуучлалын онлайн портал, гар утасны аппликэйшнаас гадна Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүд болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэх мэргэжилтнүүдийн нэвтэрч ажиллах дэд системүүдийг агуулсан томоохон хэмжээний цогц платформ юм.</p> <p>Системийн нэвтрүүлэлттэй холбоотойгоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон нийслэл, 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн нийт 301 албан хаагчдыг хамруулсан сургалтыг 2 өдрийн хугацаанд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулав.</p> <p>Энэ ондоо багтаан үлдсэн 2 дэд систем (гар утасны аппликэйшн болон хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/)-ийн хөгжүүлэлтийг бүрэн дуусгаж, үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.</p>			√	
11.	<p>-Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны хуралдааныг зохион байгуулж, 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр 08:30 цагт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хурлын танхимд эхэлж, Үндэсний хорооны дарга, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан нээж, Төрийн албан хаагчдын 2023 оны улсын төсвийн төсөлд төрийн албан хаагчдын цалин хөлсний талаар хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний талаарх танилцуулгыг гишүүдэд танилцууллаа.</p> <p>-Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны хуралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөвт төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчилж, цалин хөлсийг ажилласан жил, бүтээмж, хүрсэн үр дүнтэй уялдуулан тогтоодог болох, төрийн зарим албан хаагчдын цалин хөлсийг тодорхой хувь хэмжээгээр нэмэгдүүлэх зэрэг арга хэрэгжүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслүүдийг боловсруулсан талаарх танилцуулгыг хэлэлцүүлээ.</p>			√	
12.	<p>Төрийн албаны цалин хөлсний талаар Төрийн албаны зөвлөл, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Цагдаагийн ерөнхий газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж, санал солилцлоо. Уулзалт болон тооцоо, судалгаа, мэдээлэлд үндэслэн төрийн зарим албан хаагчдын цалин хөлсийг тодорхой хувь хэмжээгээр нэмэгдүүлэхээр дараах Засгийн газрын тогтоолын төслүүдийг боловсруулан яамдууд болон холбогдох газруудаас санал авахаар хүргүүлээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах; • “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах; • “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоол; • “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоол; 			√	

	<ul style="list-style-type: none"> “Төрийн захиргааны албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам” Засгийн газрын тогтоол. 				
13.	Хөдөлмөрийн тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.3 дахь хэсэгт заасныг үндэслэн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулав. Мөн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан, санал авахаар яамд руу 2022 оны 11 дүгээр сарын 25-ны 01/3070 албан бичгээр хүргүүлээд байна.			√	
14.	“Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”-ын төслийг танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт оролцогчдын саналын тусган МҮЭХ, МАОЭНХ-оос санал авахаар 2022 оны 11 дүгээр сарын 29-ний 02/3105 албан бичгээр хүргүүлээд байна. “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”-ын төслийг ойрын хугацаанд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.			√	
15.	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг төрийн байгууллагууд, шүүх, цагдаа, прокурор, нотариат, өмгөөллийн байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлэх ажлыг 2022.11.08-нд Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт төр, ТББ, гэр бүлийн нийгмийн ажилтнууд, өрх толгойлсон эцэг, эхийн төлөөлөл зэрэг нийт 70 гаруй хүн оролцлоо.			√	
16.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 20 орчим удаа хэлэлцүүлж, Засгийн газрын гишүүдээс санал авч сайжруулсан. Засгийн газрын бүрэлдэхүүн шинэчлэгдсэн тул хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг дахин шинэчлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгад Засгийн газрын гишүүдээс санал авч байна.			√	
17.	Засгийн Газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулав. Засгийн Газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланг боловсруулав.			√	
18.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх ажлыг хуульч зөвлөхүүдтэй хамтран зохион байгуулж байна.			√	
19.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын төсөл, танилцуулгыг залуучуудын сайн дурын ажлын удирдлага, зохион байгуулалттай холбоотой агуулгыг тусган шинэчлэн боловсруулсан.			√	
20.	“Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ын төслийг боловсруулан, СЯ, ХЗДХЯ, ЭМЯ болон цахим хэлбэрээр үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, шаардлагатай саналыг тусган, төслийг эцэслэсэн. Журмын төслийг ХЗДХЯ, ЭМЯ-нд хамтарсан тушаалаар батлуулахаар ХНХ-ын дэд сайдын 2022 оны 3/2497 албан тоотоор хүргүүлээд байна. ЭМЯ-аас санал ирсэн. ХЗДХЯ-аас ирүүлсэн саналын хүрээнд хамтран ажиллаж байна.			√	
21.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам” ХНХ-ыг сайд, ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/173, А/120 дугаар хамтарсан тушаалаар батлагдан хэрэгжиж байна. Тус журмыг шинэчилэн батлуулахаар төслийг боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлэхээр бэлтгэсэн.			√	
22.	Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны “Бодлогын шинжилгээ хийх тухай” А/234 дүгээр тушаал батлагдаж, Эрүүл мэндийн яам хамтран ажиллаж, хорт хавдартай хүүхдийн нийгмийн хамгааллын бодлого, эрх зүйн орчны судалгаа, хамгааллын зардлын тооцооллын дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулах ажлыг эхлүүлж байна.			√	
23.	Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний стандартын төсөл, Гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагын төслийг боловсруулж, батлуулахаар Стандарт хэмжил зүйн газарт албан бичгээр хүргүүлээд байна.			√	
24.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төр, төрийн бус байгууллагаас ирсэн саналыг тусган, үзэл баримтлалын төслийг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.			√	
25.	Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар холбогдох тооцоо, судалгааг хийж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн албаны			√	

	шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар"-ын төсөлд Төрийн албаны тухай хуульд заасан шалгуурыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд багасгах, шалгалтыг хялбаршуулсан байдлаар авах, босго оноог багаар тогтоох, төрийн албаны хүний нөөцөд орсон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг түрүүлж ажилд авах зэрэг саналыг боловсруулан албан бичгийн хамт хүргүүлээ.				
26.	"Насанд хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залуучуудын бие даан амьдрах чадварыг дэмжих жишиг хөтөлбөр"-т хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг чадваржуулах, амьдрах ухаан суулгах замаар хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх саналыг боловсруулан хүргүүлээ.			√	
27.	"Иргэдийг төрийн өмчийн түрээсийн орон сууцад хамруулах журам"-ын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тавигдах шаардлагыг багасгах, түрээсийн орон сууцад амьдрах хугацааг бусад бүлгээс өндөр тавих, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийг орон сууцжуулахад анхаарч ажиллах зэрэг саналыг боловсруулан хүргүүлээ.			√	
28.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам", "Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага"-ын төслүүдэд санал боловсруулан хүргүүлээ.			√	
II	Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр				
29.	АТГ-аас зохион байгуулсан "Амьжиргааг дэмжих зөвлөл /АДЗ/-ийн үйл ажиллагаа: уялдаа холбоо" сэдэвт хэлэлцүүлэгт Нийгмийн халамжийн өнөөгийн байдал, шинэчлэл сэдвээр илтгэл тавьж оролцов. Уг хэлэлцүүлгээр гарсан АДЗ-ийн үйл ажиллагаа, хэрэгжилтийн түвшинд гарч байгаа тулгамдсан асуудлыг хуулийн шинэчлэлд тусгах, мөн тус хэлэлцүүлгээс гарсан саналын дагуу 2012 онд батлагдсан АДЗ-ийн дүрмийн төслийг шинэчлэн боловсруулав.			√	
30.	Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хооронд байгуулах "Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"-ийн зээлийн хэлэлцээрийн ажлын хэсэгт БТГ-ын хэлтсийн дарга Б.Даваа-Эрдэнэ, ахлах шинжээч Д.Гэрэлтуяа нар ажиллаж УИХ-ын Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо болон Аюулгүй байдлын байнгын хороогоор хэлэлцүүлэв. Уг зээлийн хэлэлцээртэй холбоотой салбарын эрхлэх асуудлын хүрээнд хүүхдийн мөнгө, цалингийн нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголтын хэрэгжилтийн мэдээллийг бэлтгэн ажлын хэсгийн гишүүдэд өгөв.			√	
31.	АХБ-ны "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах Нийгмийн хамгаалал төсөл-2"-н хүрээнд хэрэгжиж буй "Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр"-т хамрагдах өрхийг сонгох судалгааны мэдээлэл цуглуулах арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 12 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулах юм. Үүнтэй холбоотой судалгааны ажлын удирдамжийг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан Сонгионхайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн Засаг дарга нарт хамтран ажиллах чиглэлийг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 3/3023 дугаар бүхий албан бичгээр хүргүүлэв. Ингэснээр тухайн дүүргийн ажлын хэсэг, хороодын Засаг дарга, хэлтэс албад, хэсгийн ахлагчдыг суурь судалгаанд татан оролцуулах, тэднээс дэмжлэг авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2022 оны 11 сарын 29-ний өдрийн байдлаар тус гурван дүүрэгт нийт 1581 өрхөөс судалгаа авсан буюу суурь судалгааны өрхийн мэдээлэл цуглуулалтын гүйцэтгэл 47%-тай байна. Мөн Нийслэлийн БЗД, ЧД, СХД-т хэрэгжүүлж буй "Төгсөлтийн аргачлал" туршилтын хөтөлбөр"-т сонгогдсон өрхүүдийн "Зах зээлийн судалгааны байгууллага" зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад ирүүлсэн санхүүгийн саналыг хянаж, ажиллалаа.			√	
32.	"Жайка" Олон улсын байгууллагаас нийслэлийн 2 дүүрэг, 1 аймагт туршилтын төсөл хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан цахим хуралд оролцож, төсөл хэрэгжүүлэх явц, төслийн талаар танилцаж санал солилцов.			√	
33.	Нийгмийн даатгалын өнөөгийн байдал сэдэвт нэвтрүүлгийг бэлтгэж SBN телевизээр 11 дүгээр сард олон нийтэд хүргэсэн.			√	
34.	Монголын ахмадын холбоо болон бусад холбоодоос ирүүлсэн шаардлагуудад нийгмийн даатгалын багц хуультай холбоотой тайлбар болон бусад мэдээллийг хүргүүлж байна.			√	
35.	"Журамд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолын дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлж эхлээд байна. Тайлант				

	хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/85, А/117, А/124, А/126, А/132, А/142, А/156, А/166, А/173, А/195, А/197 дугаар тушаалуудаар хүсэлт ирсэн нийт 292 аж ахуйн нэгж, байгууллагын 3829 гадаад ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийг хөнгөлөв.				
36.	Барилга, хот байгуулалтын яамнаас үндэсний ажил мэргэжлийн ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ирүүлсэн саналыг судлан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулахаар тушаалын төсөл бэлтгэв. Нийт 427 ажил, мэргэжилд нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал ирүүлсэнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/119 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх аргачлал”-ын дагуу санал нэг бүрээр судалж, европын ажил, мэргэжлийн ангиллыг жишээ болгон харьцуулан үзэж, холбогдох мэргэжлийн холбоотой уулзалт, ярилцлага хийн зөвшилцлөө.			√	
37.	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа: Хамтарсан багийн үндэсний чуулганыг 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Төрийн ордонд 800 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан.			√	
38.	Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны “Хүүхдийн эрх, хамгааллын судалгааг зохион байгуулах тухай” А/245 дугаар тушаал батлагдаж, судалгааг НҮБ-ын Хүүхдийн сан, Гүүд Нейборс Олон улсын төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулах бэлтгэл ажил эхэлсэн. Судалгааны ажлын төлөвлөгөө, аргачлалыг Ажлын хэсгээр хэлэлцүүлж, батлуулах хурлыг 2022.12.07-нд зохион байгуулна.			√	
39.	Хүүхэд харах үйлчилгээний төвүүдэд үнэлгээ хийж, хүүхдийн давхардал арилгах, санхүүжилт олгох асуудлаар ЗГХА-ГБХЗХГ, аймаг, Нийслэлийн ГБХЗХГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй цахим уулзалт хийж зөвлөгөө өгөв.			√	
40.	Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалт, байгууллага, аж ахуйн нэгжийн хүүхэд хамгааллын бодлогыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд 2022 оны 12 сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулах “сургагч багш бэлтгэх үндэсний сургалт”-ын бэлтгэл ажлыг эхлүүлж, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны “Сургагч багш бэлтгэх тухай” А/240 дүгээр тушаал батлуулсан. Тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд сургагч багш нарт зориулсан арга зүйн гарын авлагыг боловсруулж, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтарсан уулзалт 2 удаа зохион байгуулсан.			√	
41.	Хүний эрхийг хангах үндэсний хорооны анхдугаар хуралдааны үеэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын танилцуулах “Нийгмийн ажлыг бэхжүүлэх нь” илтгэлийг боловсруулж, бэлтгэв.			√	
42.	“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэшсэн ТББ-уудаар төрийн ажил, үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэх талаар санал боловсруулж хүргүүлсэн.			√	
43.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээр хийлгэх судалгааны санал боловсрууллаа.			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
44.	EU-TAIEХ хөтөлбөрийн хүрээнд Европын холбооноос Монгол Улсад суугаа төлөөлөгчийн газар, Бельги Улсын Лювенийн Их сургуулийн профессор Паул Ролес, Ив Стивенс нартай онлайн уулзалт хийв. Уулзалтаар Европын Холбооны TAIEХ (Европын Комиссын Техникийн туслалцаа, мэдээлэл солилцох) төсөлтэй 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөх үйлчилгээ авах, туршлага судлах аяллын талаар харилцан санал солилцов.			√	
45.	Нийгмийн даатгалын улсын байцаагч нарын шалгалтыг 2022 оны 11 дүгээр сарын 18-ний өдөр улсын хэмжээнд зохион байгуулав. Шалгалтад нийт 468 хүн орж 402 хүн тэнцсэн.			√	
46.	ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/188 дугаар тушаалаар байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн зарим ажилчдаас ирүүлсэн гомдлын мөрөөр хяналт, шалгалт хийх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт дараах ажлыг гүйцэтгэн ажиллав. Үүнд: <ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний төлөвлөлт, гүйцэтгэл, хүсэлт ирүүлсэн байгууллагуудын шийдвэрлэлт, ашиг сонирхол үүссэн эсэх, 			√	

	<ul style="list-style-type: none"> Төрийн байгууллагын албан мэдээлэл, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хувийн зорилгоор ашигласан эсэх, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагад ажлын цагаар ажилладаг эсэх зэрэгтэй газар дээр нь танилцан холбогдох бичиг баримтыг судлан тайлан, дүгнэлт гаргаж, тус яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хүргүүлэв. 				
47.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын тогтолцоог боловсронгуй болгохтой холбогдуулан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/183 дугаар тушаалаар баталж, ажлын хэсгийн эхний хурлыг 2022.10.07-ны өдөр зохион байгуулсан. Энэ хүрээнд дээрх журмын төсөлд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас санал авахаар яамны сайтад 30 хоногийн хугацаатай журмын төслийг байршуулав.			√	
48.	Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-н төсөлд иргэд, аж ахуй нэгж байгууллагаас санал авахаар яамны сайтад байршуулав			√	
49.	Тэтгэвэр тогтоолтын хуудсыг тэтгэвэр авагч нар англи хэлээр E-Mongolia-аас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн авдаг болов.			√	
50.	“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөө”-нд туссан “Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудыг чадавхижуулах сургалт”-ыг 2022 оны 11 дүгээр сарын 14-15-ны өдөр зохион байгуулав.			√	
51.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төв аймгийн Батсүмэр сум дахь Ахмад настны үндэсний төвд 2022 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр яамны холбогдох газар, хэлтэс, харьяа байгууллагын удирдлагуудын хамт ажиллав. Энэ хүрээнд тус төвийн үйл ажиллагаатай танилцаж, үйлчлүүлэгч, ажилтан, албан хаагчидтай уулзаж, тэдний санал хүсэлтийг сонсож, холбогдох чиглэлээр ХНХ-ын сайд газар, хэлтсийн дарга нарт үүрэг чиглэл өгөв. Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг тус төвд өнөөдрийн байдлаар 167 үйлчлүүлэгч үйлчлүүлж байна.			√	
52.	Улс, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний 12 асрамжийн газарт нийт 240 гаруй албан хаагч ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран “Төрөлжсөн асрамжийн газрын ажилтнуудыг чадавхижуулах сургалт”-ыг 2022 оны 11 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад Ахмад настны үндэсний төв, Увс, Ховд, Баян-өлгий, Хөвсгөл, Дорнод, Дорноговь, Баянхонгор аймгийн асрамжийн газрын ажилтнууд болон нийслэл хотод үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай “Ачлалт хүүхдүүд” ТББ, “Батгэрэлт ирээдүй” ТББ-ын дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн газар “МС” Тереза эх Ахмад настны асрамжийн газрын нийт 38 ажилтан хамрагдлаа.			√	
53.	Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа, бүтэц, дүрмийн талаар заасан байдаг. Нийгмийн халамжийн зарим үйлчилгээнд иргэдийг хамруулахад тухайн сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэнэ гэж заасны дагуу хуулийн хэрэгжилтийн хүрээнд 23 төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээнд тус зөвлөлөөс шийдвэр гарган ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан Авлигатай тэмцэх газраас Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрээр хэрэгждэг 23 төрлийн үйлчилгээнд шаардлагагүй үйлчилгээ байгаа эсэх талаар ХХҮГазар, хэлтэс, хороодын мэргэжилтнүүдээс судалгаа авч, судалгаатай холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газраас санаачлан 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон холбогдох албан тушаалтнууд дээрх асуудлаар санал солилцож оролцов.			√	
	Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах төрийн үйлчилгээг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төв үзүүлдэг. Тус төв гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, байнгын болон түр ажлын			√	

54.	байранд ажилд зуучлах, гэр оронтой болоход нь дэмжлэг үзүүлэх, нийгэм сэтгэл зүйн сургалт зохион байгуулах арга хэмжээнд хамруулан ажиллаж байна. НХБХЗГ-ын дарга мэргэжилтнүүд 2022 оны 11 дүгээр 04-ний өдөр тус төвд ажиллаж, төвийн дарга, ажилтнууд, үйлчлүүлэгчидтэй уулзаж тэдний санал хүсэлтийг сонсож, мэдээлэл өгч ажиллав. Нийгмийн хамгааллын тусгай төвийн өргөтгөл 5 давхар барилгыг Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Улиастайн Майхантын амд 90 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байгаа ч 2022 онд хөрөнгө оруулалтын төсөв хасагдсантай холбоотой барилгын ажил зогссон, мөн үйлчлүүлэгчдийг тээвэрлэхэд автомашин шаардлагатай байдаг гэх зэрэг тулгамдсан асуудал байгааг танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор тус яамнаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх тухай 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/2929 дугаар албан бичиг хүргүүлэв.				
55.	УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар тайланг хэлэлцүүлэхтэй холбоотой нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээлэл, танилцуулга бэлтгэв.		√		
56.	НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын тогтолцооны чадавхи бэхжүүлэх” сэдэвт сургалтыг 11 дүгээр сарын 9-11-ний өдрүүдэд Нийслэл, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн нийгмийн халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, холбогдох салбар яамд болон газруудын төлөөлөл бүхий 80 гаруй хүн оролцсон сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар байгалийн гамшигт үзэгдэлд бэлэн байх, даван туулах, цоцрол ба байгалийн гамшигт үзэгдлийн эрсдэлийн менежмент, байгалийн гамшиг, гэнэтийн хүчин зүйлд нийгмийн хамгааллын бэлэн байдлыг нэмэгдүүлэх талаар мэдлэг үр чадвар олголоо.			√	
57.	-НХБХЗГ-ын дарга мэргэжилтнүүд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийн хэрэгжилтийн байдал, халамжийн үйлчилгээний цахимжилтын явцтай танилцах зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ажиллав. Энэ үеэр Засгийн газрын тогтоол, журам, дүрмийг өөрчлөх төслийг боловсруулан анхан шатны нэгжийн саналыг тусган ирүүлэх, Ахмад настны үндэсний төв болон орон нутаг, хувийн хэвшлийн асрамжийн газруудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг үүрэг болгов. Мөн ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтын байдал, ажлын хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатайг дурдаад, сайдаас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэн, биелэлтийг хугацаанд тайлагнахыг анхааруулав. -Мөн түүнчлэн Засгийн газрын тогтоол, салбарын сайдын тушаалаар батлагдсан хөнгөлөлт, тусламж олголтыг зохицуулсан журам, дүрмийг өөрчлөх хүрээнд халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа анхан шатны нэгжийн ажлын онцлог, иргэдийг халамжийн зарим төрлийн үйлчилгээнд хамруулах эсэхийг шийдвэрлэдэг Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурал хэрхэн яаж хуралдаж шийдвэр гаргаж байгаа зэргийг судлах зорилгоор Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо болон Сүхбаатар дүүргийн 5 хороонд тус тус ажилласан.			√	
58.	Аймаг, сумдын хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн төлөөллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр болон холбогдох газрын дарга нар хүлээн авч уулзлаа. Мэргэжилтнүүдийн зүгээс халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрхэн хэрэгжүүлж байгаа болон үйлчилгээний цахимжуулалтын явц, сайн үр дүнгийн талаар удирдлагуудад танилцуулж, санал солилцов.			√	
59.	Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэнгээс тус яаманд ирүүлсэн зөвлөмжийн дагуу төрөлжсөн асрамжийн үйлчилгээний эрх зүйн орчинг сайжруулах, Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн арга хэмжээний биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 02/3059 дугаар албан бичгээр хүргүүлэв.			√	
	Халамжийн салбарын нэгдсэн бодлого, бодлогын хэрэгжилтийн уялдаа холбоог хангаж ажиллах, хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулах, төсвийн сахилга батыг сайжруулах зэрэг асуудлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт чиглэл хүргүүлэв.			√	

60.	Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6-д “ахмад настанд олгох нийтийн тээврийн хэрэгслийн төлбөрийг харьяа аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх” гэж заасан. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксианаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино. Энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг нийслэл, орон нутгийн төсөвт жил бүр тусган хэрэгжүүлнэ” гэж зохицуулсан. Үүний дагуу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн хэрэгсэлээр үнэ төлбөргүй зорчсоны төлбөрийг барагдуулах талаар аймгуудын Засаг дарга нарт 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3040 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлээ.			√	
61.	NTV, болон зарим мэдээллийн сайтуудаар СХД-ийн 34-р хороонд оршин суух өрх толгойлсон өнчин хүүхдүүд халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа талаар мэдээлэл цацагдсан. Уг мэдээллийн мөрөөр СХД-ийн 34-р хороонд болон тухайн өрхөд очиж ажилласан.			√	
62.	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2022 онд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулав. Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Батлан хамгаалахын сайд нараар 2022 оны 03 сарын 22-ны өдөр батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төслийн хүрээнд нийт 4 ээлжээр 1231 залуус төсөлд хамрагдсан. Үүний 740 эмэгтэй, 491 эрэгтэй байсан бол нийт залуусын 725 (61%) 18-25 насны, 321(27%) 25-30 насны, 158 (12%) 30-34 насны залуус хамрагдаад байна. 2022 оны 12 дугаар сард Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийн 2022 оны нэгдсэн тайлан, 2021 оны оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн мөшгих судалгааны тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдад танилцуулахаар бэлтгэн ханган ажиллаж байна.			√	
63.	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан шинэчилсэн хуулийн хүрээнд Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжүүдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Хуулийн шаардлагын дагуу 55 байгууллагын материал хүлээн авсан байна.			√	
64.	Уул уурхай, олборлох салбарт хэрэглэж байгаа уртын ээлжийн асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/164 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хуралдлаа. Ажлын хэсгийн хурлаар 2022 оны 10 дугаар сарын 16-24-ны өдрүүдэд Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, олборлох салбарын ажил олгогч, туслан гүйцэтгэгч компаниудын төлөөлөл, ажилтны төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагын ажлын үр дүн, нөхцөл байдлын талаар хэлэлцлээ. Ажлын хэсгээс шороон орд газрын төлөөлөлтэй Улаанбаатар хотод уулзалт ойрын хугацаанд зохион байгуулж, ажлын хэсгээс нэгдсэн санал дүгнэлтийг 12 дугаар сарын 10-ны дотор гаргахаар шийдвэрлэв.			√	
65.	Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн нийгмийн ажилтнуудад зориулсан: Кейс менежмент” арга зүйн сургалтыг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан.	√			
66.	“Хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил, үйлчилгээний арга зүй, кейс менежмент” сэдэвт сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулж, аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, мэргэжилтэн 110 хүн хамрагдсан.			√	
67.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж буй Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь төслийн 2022 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлангийн хуралд ХНХЯ-аас хэрэгжүүлсэн ажлаа тайлагнав.			√	
68.	Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоонд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлсэн байдлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг шилдэг аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах шагналын үзүүлэлтэд тусган хэрэгжүүлэх саналыг Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 03/3057 тоот албан бичгээр хүргүүлж, ОНЫ ШИЛДЭГ ЭНТРЕПРЕНЕР номинацид нэр дэвшигчийн шалгуур үзүүлэлтэд тусгав	√			
69.	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам хамтран Боловсролын орчин дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын судалгааг 2022-2023 оны хичээлийн жилд сургуульд суурилан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг эхлүүлсэн.			√	

70.	ЗГХА-ГБХЗХГ-тай хамтран хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг 56 ТББ-тай цахим уулзалт хийж “Хүүхэд хамгааллын үйлчилгээг магадлан итгэмжлэх журам”-ыг танилцуулж магадлан итгэмжлэл ороход шаардагдах арга зүйн сургалт хийв.			√	
71.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд “Жендэрийн талаарх залуучуудын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх нөлөөллийн контент бүтээх зөвлөх үйлчилгээ”-ний гэрээг “Ньюс Пресс Трю” ХХК болон “Дөрөв дэх өнцөг” НҮТББ-тай тус тус байгуулж, ажлыг эхлүүлсэн.			√	
72.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцлийг сайжруулах чиглэлийн холбогдох хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ авах санал, ажлын төлөвлөгөө боловсруулав.			√	
73.	Ерөнхийлөгчийн БНХАУ-д хийх айлчлалын үеэр ХНХС Т.Аюурсайханы Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спортын ордны төслийн талаарх танилцуулга мэдээллийг бэлтгэв.			√	
74.	Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын сургалтыг АНУ-ын ЭСЯ, БЗД-ийн шүүх, Конрад-Аденауэр-Сан /КАС/-ийн “Байгаль орчны чиглэлийн сэтгүүлчдийг чадавхижуулах хөтөлбөр”-ийн оролцогчид, Зориг сангийн “Залуу манлайллын хөтөлбөр”-ийн оролцогчид зэрэг нийт 120 гаруй хүнд зохион байгууллаа.			√	
75.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Хүний нөөцийн ажилтнуудад хөгжлийн бэрхшээлийн ойлголт өгөх, чадавхижуулах сургалт”-ыг ЖАЙКА ХБИ-ийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, НР-уудын холбоотой хамтран зохион байгуулж, сургалтад 30 гаруй байгууллагын 60 орчим хүний нөөц хамрагдсан.			√	
76.	-БШУЯ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний нэгдсэн зураглал боловсруулах” салбар дундын ажлын хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний зураглалыг боловсруулж хүргүүлсэн. -Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн хүрээнд Нийслэлийн зорилтод Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн салбар комиссыг чадавхижуулах сургалтыг хамтран зохион байгуулсан.			√	
77.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн өдрийг угтсан сарын аяны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллав.			√	
78.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар захирамжаар “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болон өрх, иргэний талаарх төрд байгаа мэдээлэлд тулгуурлан өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам болон өрх, хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Энэ хүрээнд ХНХ-ын сайдын 2022 оны А/189 дугаар тушаалаар төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, програм хангамж хөгжүүлэх болон Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий 2 дэд ажлын хэсгийг байгуулж, ҮСХ, ХНХЯ, СЯ, ЦХХХЯ, Монгол банк зэрэг холбогдох байгууллагууд хамтран ажиллаж байна. Дараах ажлууд хийгдсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Үндэсний статистикийн хороотой өдөр бүр үйл ажиллагааны явцын талаар мэдээлэл солилцож ажиллаж байна. • Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулах дэд ажлын хэсэг Дэлхийн банкны зөвлөхүүдийн боловсруулсан 3 аргачлалын талаар танилцан санал солилцож, цаашид хэрхэн ажиллах талаар хэлэлцсэн. • Дэлхийн банкны зөвлөхөөс шинэ аргачлалд ядуу өрхийг хэрхэн тодорхойлж байгаа талаарх судалгааг авч, танилцаж нэмэлт тооцоолол хийлгэсэн. Зөвлөхүүд эхний байдлаар тайлбар тооцоолол ирүүлснийг судалж байна. <ul style="list-style-type: none"> • ҮСХ, ХНХЯ, ЦХХХЯ-ны холбогдох албан хаагчидтай уулзаж, шинэ аргачлалыг танилцуулсан бөгөөд цаашид энэ аргачлалыг хэрхэн хэрэгжүүлэх, мэдээллийн сангуудын холбох, иргэний зөвшөөрлийг хэрхэн авах талаар хэлэлцэж, аргачлалд ашиглагдах мэдээллийн талбарыг боловсруулсаны дараа дахин хуралдахаар тохирсон. Үүний дагуу мэдээллийн талбарыг боловсруулсан. 			√	

	Дэлхийн банкны зөвлөхөөс аргачлалтай холбоотой 24 хуудас англи хэлээр бэлтгэсэн тайлантай танилцаж байна.				
79.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний А/107 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн холбогдох албан хаагчид салбарын харьяа байгууллагуудтай салбарын бүртгэл, статистик болон мэдээллийн сангийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, зөвлөн туслах, чиглүүлэх, харилцан туршлага солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлов.			√	
80.	Нийгмийн халамжийн статситикийн тайлан маягт шинэчлэхээр яамны болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын халамж хариуцсан албан хаагчидтай 2 удаа уулзалт зохион байгуулж, маягт, тайланг хэрхэн шинэчлэх талаар хэлэлцэн, маягтын төслийг боловсруулж байна.			√	
81.	ehalamj системийн өдөр тутмын үйл ажиллагаа болон олголт хийх процесс Халамжийн үйлчилгээний газар луу шилжиж байгаатай холбогдуулан Гааль, татварын мэдээллийн технологийн төв болон ХХҮЕГ-ын Мэдээллийн технологийн төвтэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж системийн зарим үйл ажиллагааг шилжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал болон шийдвэрлэх асуудлын хүрээнд санал солилцов. Олголт хийх процесстой холбоотой сургалтуудыг 11-р сарын 10,11,14-ний өдрүүдэд Гааль, татварын мэдээллийн технологийн төв дээр хийв. 11, 12-р сарын олголтын процессийг Гааль, татварын мэдээллийн технологийн төв болон ХХҮЕГ-ын Мэдээллийн технологийн төвтэй хамтран зохион байгуулах бол 2023 оны 1-р сараас ХХҮЕГ-ын Мэдээллийн технологийн төв бие даан хийнэ.			√	
82.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд олон улсын зөвлөхөөр хэтийн тооцоолол хийлгэхэд шаардлагатай тоон мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төвөөс гаргуулж, хүргүүлсэн. Хүргүүлсэн тоо мэдээллийн холбогдох ойлголт тодорхойлолтыг цахимаар холбогдож тайлбарласан бөгөөд 2006-2022 эхний хагас жилийн нийгмийн даатгал шимтгэл төлөгч иргэдийн мэдээллийн нууцлалыг хангаж хүргүүлсэн. Мөн тэтгэвэр авагч иргэний мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас хүлээн авч хянан шалгаж, мэдээллийг НДЕГ-аас хүлээн авч, гадаадын зөвлөхөд хүргүүлсэн.			√	
83.	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн аж ахуй, нэгж байгууллагын сарын дундаж цалингийн тайлан маягтыг мөрдүүлэх хугацааг хойшлуулах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас албан бичиг ирсэнийг Үндэсний статистикийн хороонд хүргүүлэв.			√	
84.	ЦХХХЯ-наас 11-р сарын 4-нд зохион байгуулсан Цахим шилжилтийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сэдэвт хэлэлцүүлэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын цахим шилжилт сэдвээр мэдээлэл бэлтгэж оролцов.			√	
85.	ЦХХХЯ-наас боловсруулан ирүүлсэн “Дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээлэл”, “Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага”-ын төслүүдтэй танилцаж дэмжсэн санал өгөв.			√	
86.	Хөдөлмөрийн зах зээлийн eJob системийн нээлт хийхэд зайлшгүй бэлэн болгох хэсгүүдийн талаар уулзалтыг гүйцэтгэгч талтай хийлээ. Мөн системд хэрэглэгчид мэдээлэл хүргэх цахим шуудангийн холболт болон Дан системээр дамжуулан байгууллагыг тоон гарын үсгээр нэвтрэх хэсэгтэй холбоотой сервес нэмэх асуудлын зохион байгуулалтыг хийв.			√	
87.	УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороонд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт, цаашдын зорилт болон Хүний эрхийг хангах үндэсний хорооны анхдугаар хуралдаанд Нийгмийн ажлыг бэхжүүлэх нь талаар ХНХ-ын сайд танилцуулж, мэдээлэл хийв.		√		